



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2024 оны 06 дугаар сарын 03
№21 (1317)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

255.	Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 24	827
256.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай	Дугаар 27	870
257.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 35	888
258.	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 37	890
259.	Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 38	902
260.	Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай	Дугаар 39	908



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 24

Улаанбаатар
хот

Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 9 дүгээр тогтоолоор байгуулагдсан “Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох хороодын өгсөн зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ”-г хавсралтаар баталсугай.

2.Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

а/Нэгдсэн Үндэстний Байгууллагын Арьс үндсээр алагчлах үзлийг устгах хороо, Эрүү шүүлтийн эсрэг хороо, Хүчээр алга болгохын эсрэг хороонд манай улсын иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хянан хэлэлцэх эрхийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдлийг хүргүүлэх;

б/Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийг хариуцах төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, мэдээлэл дамжуулах, солилцох мэдээллийн нэгдсэн цахим санг бий болгох;

в/Монгол Улсын олон талт олон улсын гэрээ болон холбогдох тайлбаруудыг орчуулж, хэвлэн нийтлэх, олон улсын гэрээний хэрэгжилт харуулсан төрийн албан хаагчдыг чадавхжуулах, олон улсын гэрээний талаарх иргэдийн боловсролыг дээшлүүлэх, олон улсын гэрээний зүйл, заалтын практик хэрэглээг бий болгох зорилгоор хуульчдад зориулсан сургалтыг тогтмол зохион байгуулах, гэрээний хэрэгжилтийг тайлагнахад шаардагдах зардлыг төсөвт тусгуулах арга хэмжээ авах;



г/энэ тогтоолын хавсралтад дурдсан асуудлаар эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Олон улсын гэрээний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

д/олон улсын гэрээ хэлэлцээрт нэгдэн орсноор Монгол Улсад үзүүлэх үр нөлөө, хүлээх үүрэг хариуцлагын талаар урьдчилан судалж, дүн шинжилгээ хийх эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

4.Энэ тогтоолыг 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын 2024 оны
24 дүгээр тогтоолын хавсралт

**ОЛОН ТАЛТ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗОРИЛГООР
ХОЛБОГДОХ ХОРООДЫН ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

№	Гэрээний нэр	Гэрээний хорооноос өгсөн зөвлөмж	Зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Агуулга
		Нэг.Гадаад харилцааны яамны эрхлэх асуудлын хүрээнд:		
		<p>Арьс үндсээр алагчлах үзлийг устгах хорооны 2015 оны 15, 2019 оны 12 дугаар зөвлөмж:</p> <p>Арьс үндсээр ялгаварлан гадуурхаж үзэн ядсан үг хэллэгийг хориглох, түүнтэй тэмцэх заалтыг хууль тогтоомжид оруулах.</p>	<p>Эрүүгийн хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Эрүүгийн хуулийн 14.1-д заасан "ялгаварлан гадуурхах" гэмт хэргийн тодорхойлолт, субъектийг конвенцод бүрэн нийцүүлж, конвенцод заасан арьс үндэсний дээрэнгүй буюу үзэн ядах санааг дэлгэрүүлэх, өдөөн турхирах, санхүүжүүлэх болон бусад байдлаар туслалцаа үзүүлэх, аливаа хүн, бүлэг хүмүүс буюу байгууллагаас явуулж буй арьс үндсээр алагчлах үзлийг дэмжих ажиллагаа, суртал ухуултыг хориглох, энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага, үйл ажиллагаанд оролцохыг гэмт хэрэгт тооцох.</p>
1.	<p>Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц</p>	<p>Арьс үндсээр алагчлах үзлийг устгах хорооны 2006 оны 23, 2015 оны 29, 2019 оны 30 дугаар зөвлөмж:</p> <p>НҮБ-ын ЕА-н зүгээс Хороог санхүүжүүлэх тухай Конвенцын нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах.</p>	<p>НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Ассамблейн зүгээс Хороог санхүүжүүлэх тухай Конвенцын нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцын нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах.</p>



	<p align="center">Хоёр.Хууль зүй, дотоод хэргийн яамны эрхлэх асуудлын хүрээнд:</p>						
<p>Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Түүний Нэмэлт II протокол</p>	<p>НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2017.07.24-ний өдрийн CAT/MNG/CO/2 зөвлөмж:</p> <p>(10)Оролцогч улс нь шууд болон шууд бус байдлаар ялгаварлан гадуурхах эсрэг төрийн болон хувийн салбар дахь ялгаварлан гадуурхах байдлад чиглэсэн ялгаварлан гадуурхахын эсрэг дэлгэрэнгүй зохицуулалт бүхий хууль тогтоомжийг батлах шаардлагатай, эдгээр хууль тогтоомж нь шүүхийн болон захиргааны журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд эрхийг хамгаалах үр дүнтэй хамгаалах хэрэгсэл болох ёстой.</p>	<p>НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2017.07.24-ний өдрийн CAT/MNG/CO/2 зөвлөмж:</p> <p>(21)Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах алба, Авлигатай тэмцэх газар эрүү шүүлт тулгасан хэргийг мөрдөн шалгахад бие даасан байдал хангалтгүй байгаад анхаарал хандуулахыг Хорооны зүгээс хүсэж байна. (2, 7 дугаар зүйлүүд)</p> <p>Оролцогч улс нь эрүү шүүлт үйлдэгдсэн талаар мөрдөн байцаалт явуулах өөрийн улсын бүх механизм бие даасан, хараат бус байдалтай ажиллаж буй эсэхийг нягтлах ёстой.</p>	<p>Ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалт бүхий хууль тогтоомжийг эрүү шүүлт тулгах үйлдсэн эрүү шүүлт тулгах, зүй бус харьцсан зэрэг үйлдлийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй, хараат бус бие даасан нэгжийг байгуулах.</p>	<p>Ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалт бүхий хууль тогтоомжийг эрүү шүүлт тулгах үйлдсэн эрүү шүүлт тулгах, зүй бус харьцсан зэрэг үйлдлийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй, хараат бус бие даасан нэгжийг байгуулах.</p>	<p>Төрийн алба хаагчид, түүний дотор цагдаагийн албан хаагчдын үйлдсэн эрүү шүүлт тулгах, зүй бус харьцсан зэрэг үйлдлийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй, хараат бус бие даасан нэгжийг байгуулах.</p>	<p>Төрийн болон хувийн салбарт шууд болон шууд бус байдлаар ялгаварлан гадуурхахын эсрэг дэлгэрэнгүй зохицуулалт бүхий хууль тогтоомжийг батлах, эдгээр хууль тогтоомж нь шүүхийн болон захиргааны журмаар хэрэг хянан шийдвэрлэхэд хүний эрхийг хамгаалах үр дүнтэй хэрэгсэл байх;</p>	<p>Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хараат бусаар мөрдөн шалгах бие даасан тогтолцоо бүрдүүлэх.</p>
<p>2.</p>							

	<p>НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2017.07.24-ний өдрийн САТ/МНГ/СО/2 зөвлөмж:</p> <p>(34)Орлоцогч улс нь хүүхдийн нас, тусгай хэрэгцээ, хууль зөрчсөн хүүхдийн эмзэг байдал зэргийг харгалзан насанд хүрээгүй хүүмүүсийг шүүх цогц, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэхэд гаргаж байгаа хүчин чармайлтаа эрчимжүүлэх шаардлагатай байна.</p>	<p>Насанд хүрээгүй хүмүүсийн хүүмүүсийн үйлдсэн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанаас эхлээд харууцлага хүлээлгэх бүх үе шатанд хүүхдийн эрхийг хамгаалах тогтолцоог бий болгож, шаардлагатай стандарт, журмыг боловсруулж батлах.</p>	<p>Эрүүгийн хэрэг болон зөрчил шалган шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх бүх үе шатанд хүүхдийн эрхийг хамгаалах, тэдэнд тохирсон стандартыг нэвтрүүлэх;</p>
	<p>НҮБ-ын Хүний эрхийн хорооны 2017.07.24-ний өдрийн САТ/МНГ/СО/2 зөвлөмж:</p> <p>(34)Түүнчлэн зохих хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжоор насанд хүрээгүй хүүмүүс хангагдсан эсэхийг нягтлах, цагдан хорих болон хорих арга хэмжээг түүнд авч болох бүх арга хэрэгслийг хэрэглэсний дараа эцсийн арга болгон хамгийн богино хугацаагаар хэрэглэх, насанд хүрсэн хоригдлуудаас тусгаарлан байрлуулж буйг хянан нягтлах ёстой.</p>	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Өсвөр насны хүүхдэд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ оногдуулахаас өөр таслан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p>
	<p>Цагдан хорих болон хорих хэмжээг түүнд авч болох бүх арга хэрэгслийг хэрэглэсний дараа эцсийн арга болгон хамгийн богино хугацаагаар хэрэглэх;</p>		<p>Хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжоор насанд хүрээгүй хүүмүүс хангагдсан эсэхийг нягтлах, цагдан хорих болон хорих арга хэмжээг түүнд авч болох бүх арга хэрэгслийг хэрэглэсний дараа эцсийн арга болгон хамгийн богино хугацаагаар хэрэглэх, насанд хүрсэн хоригдлуудаас тусгаарлан байрлуулж буйг хянан нягтлах;</p>



	<p>НҮБ-ын Хүний Эрхийн хорооны 2017.07.24-ний өдрийн САТ/ММГ/СО/2 зөвлөмж:</p> <p>(38) Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх тухай Хорооны ерөнхий тайлбар №34 (2011)-өөс Үүдэн хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд аливаа хязгаарлалт тавихгүй байх, Пактын 19 (3) дугаар зүйлд заасантай нийцэж буй эсэхийг оролцогч улс нь нягтлах ёстой.</p> <p>Гүтэлийг бүрэн утгаар нь эрүүгийн хуулиас хасаж, гэмт хэрэгт тооцоггүй байх, гүтгэлэг нь эрх чөлөөг хязгаарлах үндэслэл болохгүй байх, эрүүгийн болон иргэний хууль тогтоомжид заасан гүтгэлийн талаарх зохицуулалтууд нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг боогдуулахгүй байх ёстой талаар эргэцүүлэх шаардлагатай.</p>	<p>Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн/шинэчилсэн найруулга/ төсөл, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид тусган боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16/-д заасан "итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх" эрх чөлөөг хамгаалах;</p>
<p>Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар букуу доромжлон хүний нэр төрийг харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын протокол</p>	<p>НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 2016.08.09-ний өдрийн САТ/ММГ/СО/2 зөвлөмж:</p> <p>Конвенцын 1 дүгээр зүйлийн бүх элементийг агуулсан эрүүдэн шүүх тодорхойлолтыг батлах. Үүнд: эрүү шүүлт тулгах сэдэл, эсхүл шалтгаан, гутаан доромжлох, шахалт үзүүлэх шалтгаан зэрэг нь гуравдагч этгээдэд ч хамааралтай байхаар зааж оруулсан байх.</p>	<p>Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах эрүүгийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Эрүүгийн хуулийн 21.12 дэх хэсгийг "эрүү шүүлт тулгах сэдэл эсхүл шалтгаан, гутаан доромжлох, шахалт үзүүлэх шалтгаан зэрэг нь гуравдагч этгээдэд ч хамааралтай байх" тухай;</p>
<p>3.</p>			



	<p>НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг хорооны 2016.08.09-ний өдрийн SAT/С/М/М/Г/СО/2 зөвлөмж: 24. Оролцогч улс нь: (а) "Насанд хүрээгүй этгээдийг шүүхэд баримтлах дүрэм журмын наад захын" стандарт (Бээжингийн дүрэм) болон НҮБ-ын Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх удирдамж (Руадан-ын удирдамж) зэрэг олон улсын стандарт жишигт нийцсэн насанд хүрээгүй хүмүүсийг шүүх үр дүнтэй, мөргэшсэн, сайн ажиллагаатай тогтолцоог бий болгох асуудлыг авч үзэх.</p>	<p>Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн хэргийг хянан шийдвэрлэх, ажиллагаанаас эхлээд хариуцлага харууцлага хүлээлгэх, хэрэг хянан шийдвэрлэх бүх шатанд хүүхдийн эрхийг хамгаалах тогтолцоог бий болгож, холбогдох дүрэм, журам, стандартыг боловсруулж, батлах.</p>	<p>Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хариуцлага хүлээлгэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хүүхдийн эрхийг хамгаалах, үр дүнтэй, мөргэшсэн, сайн ажиллагаатай тогтолцоог бий болгох.</p>
	<p>НҮБ-ын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал харуулсан Дэд хорооны 2018.03.09-ний өдрийн SAT/ОР/М/М/Г/Р.1 тайлан: 29)Төрийн алба хаагчид, түүний дотор цагдаагийн албан хаагчдын үйлдсэн эрүү шүүлт тулгах, зүй бус харьцсан зэрэг үйлдлийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй, хараат бус бие даасан нэгжийг Улсын ерөнхий прокурорын газрын дотоод бүтэцэд дахин бий болгохыг оролцогч улсад Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал харуулсан дэд хорооноос зөвлөж байна.</p>	<p>Төрийн алба хаагчид, түүний дотор цагдаагийн албан хаагчдын үйлдсэн эрүү шүүлт тулгах, зүй бус харьцсан зэрэг үйлдлийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй, хараат бус бие даасан нэгжийг байгуулах.</p>	<p>Тусгай субъектийн үйлдсэн хэргийг мөрдөн шалгах үр дүнтэй тогтолцоо бий болгох;</p>



	<p>НҮБ-ын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх асуудал харуулсан Дэд хорооны 2018.03.09-ний өдрийн САТ/ОР/МНГ/Р.1 тайлан:</p> <p>56)Хуульд заасан хугацаанаас хэтрүүлэн захиргааны журмаар албадлага хэрэглэн түр хугацаагаар саатуулж байгааг оролцогч Улс нягтлахыг ЭШУСДХ-ны зүгээс зөвлөж байна. Захиргааны зөрчил гаргасны төлөө албадан саатуулах тогтоолыг бүрэн хэмжээгээр зохих ёсоор шүүхийн хяналт доор гаргах ёстой бөгөөд саатуулагдсан этгээдүүд эрх зүйн бүхий л хамгаалалт эдлэх болмжоор хангагдах шаардлагатай. Захиргааны журмаар албадан саатуулах тогтоолд томдол гаргах үр дүнтэй арга хэрэгслийг бодит байдалд бий болгох нь зүйтэй.</p>	<p>Эрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зөвшөөрлийн дагуу гүйцэтгэх, түүнчлэн албадан саатуулах тухай шийдвэрт томдол гаргах үр дүнтэй арга хэрэгслийг бий болгох;</p>	<p>Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлд заасан "хүчээр алга болгох" гэмт хэргийн тодорхойлолт, субъектийн хамрах хүрээг конвенцын тодорхойлолтой нийцүүлэх, мөн "нууцаар хорих" асуудал уг гэмт хэргийн зүйлчлэлд багтсан эсэхийг нягталж, хориглох зохицуулалтыг бий болгох;</p>
<p>4.</p> <p>Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенц</p>	<p>Хүчээр алга болгохын эсрэг хорооноос өгсөн 2021.05.06-ны CED/С/МНГ/СО/1 зөвлөмж:</p> <p>(16)Нэгд, одоогийн тодорхойлолтод эрх чөлөөг хязгаарлах бүх хэлбэрийг тусгааргүй, зөвхөн хууль бусаар хорих үйлдлийг хамруулсан байна. Хүчээр алга болгох гэмт хэргийг хүний эрх чөлөөг хууль ёсны дагуу хязгаарлаж эхлүүлээд дараа нь уг гэмт хэргийн бусад элемент, шинж давхар гарч ирснээр хууль бус болдог.</p> <p>Хоёрт, Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх эсгийн 2 дахь заалтыг мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий этгээд, прокурор болон шүүгчид хамаарахаар заасан нь Конвенцын 2 дугаар зүйлд заасан төрийн агент болон төрөөс эрх олгогдсон, дэмжлэг буюу зөвшөөрөл авсан этгээдүүд, эсхүл бүлэг этгээдийг орхигдуулж байна. (Конвенцын 2-4 дүгээр зүйл)</p>	<p>Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	

	<p>Хүчээр алга болгохын эсрэг хорооноос өсөн 2021.05.06-ны CED/C/MNG/CO/1 зөвлөмж:</p> <p>(18)Эрүүгийн хуулийн 29.5 дугаар зүйлд төрлөөр устгах гэмт хэргийн тодорхойлолтод хүчээр алга болгох гэмт хэргийг тусгасан байх бөгөөд Хороо нь дотоодын хууль тогтоомжид хүчээр алга болгох түгээмэл дэлгэрсэн буюу тогтолцоо бүхий дадлыг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцохыг зөвлөж байна. (5 дугаар зүйл)</p>	<p>Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлд заасан “хүчээр алга болгох” гэмт хэргийг хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт тооцох буюу Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэгт шилжүүлэх;</p>
	<p>Хүчээр алга болгохын эсрэг хорооноос өсөн 2021.05.06-ны CED/C/MNG/CO/1 зөвлөмж:</p> <p>(22)Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлд заасан хүчээр алга болгох гэмт хэрэгт онгодлуулах ял шийтгэл нь торгох ялаас 12 хүртэл жил хорих ялаар шийтгэхээр байгаа нь гэмт хэргийн онц ноцтой байдалд тохирохгүй байна. Гэхдээ, хүчээр алга болгох гэмт хэргийн Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлд заасан тусгай хүндрүүлэх нөхцөлүүд болон уг хуулийн 6.6 дугаар зүйлд заасан хүндрүүлэх нийтлэг нөхцөлүүдэд Конвенцын 7(2) дугаар зүйлд заасан хөгжлийн бэрхшээлтэй, өөр бусад эмзэг бүлгийн хүмүүсийг хүчээр алга болгох тохиолдлуудыг оруулаагүй байна.</p>	<p>Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Эрүүгийн хуулийн “Хүнийг хүчээр алга болгох” гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлүүдэд хөгжлийн бэрхшээлтэй, бусад эмзэг бүлгийн хүмүүсийг хүчээр алга болгох тохиолдлуудыг нэмж Тусгах;</p>



	<p>Хүчээр алга болгохын эсрэг хорооноос өгсөн 2021.05.06-ны CED/C/MNG/CO/1 зөвлөмж:</p> <p>(22)Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйлд заасан хөнгөрүүлэх нөхцөлд Конвенцын 7(2)(а) дугаар зүйлтэй нийцүүлэн "Хүчээр алга болгогдсон этгээдийг амьдаар нь буцаах" гэж заасныг тусгайлан тусгах. Хуулийн төсөлд заасан ял, шийтгэлийг онцлон тэмдэглэсэнээр Хорооноос эдгээр нь хүндэрүүлэх нөхцөлтэй байсан ч 1 жил хүртэл хорих ялаар онцгойлон сонгох боломжтой байдал нь хүчээр алга болгох гэмт хэргийн хүндрүүлсэн хэлбэртэй, тохирохгүй байна гэж үзэж буйг давтан илэрхийлж байна.</p> <p>Хүчээр алга болгохын эсрэг хорооноос өгсөн 2021.05.06-ны CED/C/MNG/CO/1 зөвлөмж:</p> <p>(27)Хороо эрх бүхий байгууллагаас хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэг гэж бүртгэгдсэн бүх хэргүүдэд цаг алдалгүй, бүрэн гүйцэт, хараат бусаар мөрдөн явуулдаг байдлыг хууль эрх зүйн болон шалгах ажиллагааг системтэйгээр практикт хангах хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 171.1 дүгээр зүйлд заасан эрүүгийн хэрэг үүсгэх 5 өдрийн хугацааг эргэж харахыг оролцогч улсад зөвлөж байна. Оролцогч улс эрүүгийн хэрэг мөрдөн шалгах, яллах үүрэгтэй эрх бүх байгууллагыг бүрэн хараат бус, бие даан ажиллах байдлыг хангах. Мөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүрэн эрхээс прокурорыг томилох, чөлөөлөх асуудлыг хасах.</p>	<p>Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Конвенцын 7(2)(а) дугаар зүйлтэй нийцүүлэн Эрүүгийн хуулийн "Хүнийг хүчээр алга болгох" гэмт хэргийн хөнгөрүүлэх нөхцөлүүдэд "хүчээр алга болгогдсон этгээдийг амьдаар нь буцаах" тохиолдлыг нэмж тусгах;</p>
	<p>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэг нь олон улсын эрх зүйн хэм хэмжээнд тодорхойлсноор "хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг"-т тооцогдох тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын харьяаллыг өөрчлөх;</p>	



<p>Хүчээр алга болгохын эсрэг хорооноос өссөн 2021.05.06-ны CED/C/MNG/CO/1 зөвлөмж: (29) Хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа хууль сахиулах, эсхүл төрийн тусгай чиг үүргийн байгууллагын (аюулгүй ажиллагааны) алба хаагчийн албаны бүрэн эрхийг мөрдөн шалгах ажиллагааг дуустал түдгэлзүүлж, холбогдох мөрдөн шалгах ажиллагаанд оролцохгүй байх баталгааг эрх зүйн болон практик ажиллагаанд хангах;</p>	<p>Эрүүгийн хэрэг янхан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Хүнийг хүчээр алга болгох хэрэгт сэжиглэгдэж байгаа хууль сахиулах чиг үүргийн тусгай чиг үүргийн байгууллагын алба хаагчийн албаны бүрэн эрхийг мөрдөн шалгах ажиллагааг дуустал түдгэлзүүлж, холбогдох мөрдөн шалгах ажиллагаанд оролцохгүй байх баталгааг хууль, эрх зүйн орчинд болон практик үйл ажиллагаанд хангах;</p>
<p>Хүчээр алга болгохын эсрэг хорооноос өссөн 2021.05.06-ны CED/C/MNG/CO/1 зөвлөмж: (31) (а) Хүнийг хүчээр алга болгох аюулд өртөх магадлалтай гэж үзэх үндэслэл байгаа тохиолдолд түүнийг албадан гаргах, буцаах, хүлээлгэн өгөх, гэмт этгээдээр шилжүүлэн өгөхийг хориглосон заалтыг дотоодын хууль тогтоомжид тодорхой тусгах асуудлыг авч үзэх;</p>	<p>Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг янхан шийдвэрлэх тухай хууль, Гэрч, хохилогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Хүнийг хүчээр алга болгох аюулд өртөх магадлалтай гэж үзэх үндэслэл байгаа тохиолдолд түүнийг албадан гаргах, буцаах, хүлээлгэн өгөх, гэмт этгээдээр шилжүүлэн өгөхийг хориглох, түүнчлэн гэмт хэргийн хохилогчийн эмгөөлгөчөөр оролцсоны улмаас заналхийлэх, сүрдүүлэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалалтад авах асуудлыг Гэрч, хохилогчийг хамгаалах тухай хуульд тусгах;</p>
<p>б) Хүчээр алга болсон хүний эрсдэлийг үнэлэх албадан гаргах, буцаах, хүлээлгэн өгөх, гэмт этгээдээр шилжүүлэн өгөх журмын хүрээнд гаргасан аливаа шийдвэрийг давж заалдах боломжтой болгож, уг давж заалдах гомдлыг түдгэлзүүлж болгох баталгаагаар хангах;</p>	<p>Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг янхан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Хүчээр алга болсон хүний эрсдэлийг үнэлэх албадан гаргах, буцаах, гэмт этгээдээр шилжүүлэн өгөх журмын хүрээнд гаргасан аливаа шийдвэрийг давж заалдах боломжтой болгож, уг давж заалдах гомдлыг түдгэлзүүлж болгох баталгаагаар хангах;</p>



	<p>Хүчээр алга болгохын эсрэг хорооноос өгсөн 2021.05.06-ны CED/C/MNG/CO/1 зөвлөмж:</p> <p>43(а)Конвенцын 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүчдийг хүчээр алга болгохтой холбоотой бүх үйлдлийг гэмт хэрэгт тооцох тухай хуулийн зохицуулалт байхгүй байна. Эдгээр үйлдлийг тусгайлан гэмт хэрэгт тооцох болон гэмт хэргийн онц ноцтой байдлыг харгалзан зохих ял шийтгэлийг оногдуулах зорилгоор өөрийн Эрүүгийн хууль тогтоомжийг нягтлах.</p>	<p>Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Хүүхдийг хүчээр алга болгохтой холбоотой бүх үйлдлийг гэмт хэрэгт тооцох, онц ноцтой байдлыг нь харгалзан ялын бодлогыг чангаруулах;</p>
<p>Гурав. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эрхлэх асуудлын хүрээнд:</p>			
<p>Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц</p>	<p>Үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тайлагналтыг чанаржуулах.</p>	<p>Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон талт олон улсын гэрээ, конвенцод тухайн асуудлаар Үндэсний хөтөлбөрүүдийг батлуулах, хэрэгжүүлэх, тодорхой санхүүжилтийг хэрэгжүүлэх зорилгоор олгодог тул дэмжих зорилгоор олгодог тул Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн үйлчлэлд Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх хүрээнд батлах хөтөлбөрүүдийг хамааруулахгүй байх;</p>
<p>Удаан задрдаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц</p>	<p>Үндэсний хөтөлбөрийг шинэчлэх, шинээр бүртгэгдсэн бодисын жагсаалтыг батлах.</p>	<p>Олон улсын гэрээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Олон улсын олон талт гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт, тайлагналт, салбар дундын зохицуулалт, хэрэгжилтийг хангах, зардлын тухай;</p>
<p>Амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц</p>	<p>САИТИС-ын нарийн бичгийн дарга нарын газраас 2019, 2022 ирүүлсэн зөвлөмж:</p> <p>Дотоодын хууль тогтоомжийг конвенцын заалт болон шийдвэрүүдтэй нэн даруй нийцүүлэх, чингэхдээ конвенцын хуулийн багтай ажиллах.</p>		

Дөрөв.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхлэх асуудлын хүрээнд:	
<p>Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, түүний протокол</p>	<p>31(е)Ахлын байран дахь бэлгийн дарамтыг тусгайлан гэмт хэрэгт тооцохоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, ажил ологч, ажилтнуудын бэлгийн дарамтын талаар болон Жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих тухай хуулийн холбогдох заалтаар ойлголт өгөх, бэлгийн дарамтын талаарх бүх мэдээллийг сайтар шалгах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэмт хэргийн шинжтэй хариуцлага тооцох зохих шийтгэл ногдуулж, ОУХБ-ын 2019 оны (№190) Хүчирхийлэл, дарамтын тухай конвенцод нэгдэх асуудлыг авч үзэх.</p>
<p>8.</p>	<p>Холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p> <p>ОУХБ-ын 2019 оны (№190) Хүчирхийлэл, дарамтын тухай конвенцод нэгдэн орох;</p>
<p>9.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, түүний нэмэлт протокол</p>	<p>Холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p> <p>Холбогдох хууль тогтоомж, бодлогыг Конвенцод болон түүнтэй хамааралтай зүйл заалтуудад нийцүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхэм зэргийг болон тэднийг бусдын нэгэн адил нийгэмд үр дүнтэй, бүрэн дүүрэн оролцоход саад болдог төрөл бүрийн саад бэрхшээлүүдийн харилцан үйлчлэлээс бий болдог нөхцөл байдлыг онцолж үздэг хүний эрхийн загварыг хэрэглэх.</p> <p>Хүмүүнлэгийн яаралтай тусламж болон эрсдэлийн нөхцөл байдалд туслах үндэсний төлөвлөгөө боловсруулах, түүнийг бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, түүн дотроос сонголтгүй хүмүүст хүртээмжтэй байх ёстойг Хороо оролцогч улсад зөвлөж байна. Тараах материал нь хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэгдэж гараагдах ёстой.</p>
	<p>Бэлгийн дарамтын талаарх бүх мэдээллийг сайтар шалгах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зохих шийтгэл оногдуулах;</p> <p>ОУХБ-ын 190 дугаар конвенцод нэгдэн орох;</p> <p>Конвенцын дагуу "Хөгжлийн бэрхшээлт" гэсэн нэр томьёог тодорхой, ойлгомжтой, нэг мөр болгох;</p> <p>Гамшгаас хамгаалах тухай хуульд аврах үйл ажиллагааны үеэр хөгжлийн бэрхшээлтэй болсон алба хаагчдад тэтгэмж үзүүлэх тухай 3 заалт байдаг боловч хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хэрхэн гамшиг, ослоос хамгаалах, урьдчилан сэргийлэх тухай зохицуулалт байхгүй. Иймд холбогдох хуульд зохицуулалтыг тусгах;</p>



	<p>Хөгжлийн бэрхшээлээс нь болж алагчлах талаар анхааралдаа авч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой бүх хууль тогтоомжид үл алагчлалын ойлголтыг бодитоор хэрэгжүүлж, холбогдох бүх хуулиудад оруулахыг хөрсөлдөж байна. Мөн Хороо оролцогч улсад зөвлөж байна. Мөн бүх хуулиудад хөгжлийн бэрхшээлээс тохирох хэрэглэгдэхүүнийг (reasonable accommodation) баталгаажуулсан хуультай болохыг зөвлөж байна. Мөн энэхүү хуулийг дагаж мөрдөх үр дүнтэй мониторингийн механизмыг бий болгохыг зөвлөж байна. Үүнд хөгжлийн бэрхшээлээс нь болж алагчлахад холбогдох нөхөн олговор болон төлбөр хайхад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст боломж олгох ёстой. Мөн оролцогч улсын болон хувийн салбарт ажиллаж байгаа хүмүүст, түүн дотроос шүүхийн хүмүүст, төрийн албан хаагч болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын төлөөлд хөгжлийн бэрхшээлээс болж алагчлах талаарх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохирох хэрэглэгдэхүүн (reasonable accommodation)-ээр хангах үүрэг болон боломжуудын талаар тохирох шаардлагатай сургалтыг зохион байгуулахыг санаачлахыг зөвлөж байна.</p>	<p>Соёлын тухай, Номын сангийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний Өргөн нэвтрүүлгийн тухай, Гамшгаас бэрхшээлийн хэлбэрт тохирсон тоног хамгаалах тухай, Гэр бүлийн тухай, төхөөрөмж, орчин, туслах хэрэгсэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бодлогын орчин зэргийн тусламжтай тухай, Боловсролын тухай хуульд бусдын адил сурч боловсрох, нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн хөдөлмөр эрхлэх зэрэг нийгмийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх. харилцаанд бие даан оролцох эрхийг баталгаажуулах зохихуулалтыг холбогдох хууль тогтоомжид тусгах;</p>
--	---	--

	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмд оролцох оролцоог нэмэгдүүлэхийн тулд мэдээлэл, харилцааны хүртээмжтэй технологи ашиглахад учирч буй саад бэрхшээлийг арилгаж, хүртээмжийн талаарх бодлогоо өргөжүүлэхийг Хороо оролцогч улсад зөвлөж байна. Дохионы хэл болон Брайлын хууль ёсны болгож, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүртээмжтэй, олон төрлийн контентуудын тоо хэмжээг ихэсгэхийг оролцогч улсад зөвлөж байна. Мөн нийтийн тээвэр, барилга, байшин, нийтийн орон зайд хүртээмжтэй байдлыг баталгаажуулах арга хуваарилалтыг ихэсгэхийг оролцогч улсад Хороо зөвлөж байна. Мөн хүртээмжийн талаар мониторинг үнэлгээ, албадан хэрэгжүүлэх механизмыг сайжруулахыг зөвлөж байна. Хүртээмжийн талаарх Хорооноос гаргасан Ерөнхий зөвлөмж №2 (2014) болон Конвенцод нийцүүлэн хууль тогтоомжид заасан хүртээмжийн стандартыг биелүүлээгүй тохиолдолд тохирох шийтгэл (санц) оногдуулах ёстой.</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй Хөгжлийн хүртээмжтэй орчин нөхцөл бүрдүүлэх; Хүнд болон Дохионы хэлний тухай хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>
--	--	---



	<p>1.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний үндсэн үүрэг нь хөдөлмөрийн зах зээлийн хамгийн боломжтой шилдэг зохион байгуулалтыг хүн амын бүрэн хөдөлмөр эрхлэлтийг бий болгож, бэхжүүлэх ба үйлдвэрлэх хүчийг хөгжүүлж, ашиглахад чиглэсэн үндэсний хөтөлбөрийн салшгүй хэсэг болгон шаардлагатай үед төрийн болон хувийн хэвшлийн холбогдох этгээдүүдтэй хамтран хангах явдал мөн.</p> <p>2.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ нь үндэсний эрх бүхий байгууллагын удирдлага доор ажиллах хөдөлмөрийн товчооны үндэсний тогтолцооноос бүрдэнэ.</p>	<p>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p> <p>1.Төр-хувийн хэвшлийн Түншлэлийг хөгжүүлэх үндсэн дээр хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний зохион байгуулалтыг хангах, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх Үндэсний хөтөлбөр, макро эдийн засгийн арга хэмжээ, хөдөлмөрийн зах зээлийн боломжит шилдэг зохион байгуулалт, эрэлт, хэрэгцээг хангах, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зохион байгуулалт, ажилтны эрх, үүрэг, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ эрхлэх төрийн үйлчилгээний байгууллага байгуулах, ажиллуулах;</p> <p>2.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнууд нь төрийн албан хаагчид байх бөгөөд тэдний эрх зүйн газрын өөрчлөлт болон гаднын зүй бус нөлөөлөөс хараат бус байх, тухайн албаны шаардлагад нийцсэн хэмжээнд тогтвортой ажлын байраар хангагдсан байх;</p>
<p>10. Ажил эрхлэлтийн үйлчилгээний тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 88 дугаар конвенц</p>	<p>3.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулж, үйл ажиллагааг нь хангах, мөн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний бодлогыг боловсруулахад ажил олгогчид ажиллуулахын тулд зөвлөх хороодын тусламжтайгаар зохих арга хэмжээ авна. -Ийм арга хэмжээний хүрээнд нэг буюу түүнээс дээш үндэсний зөвлөх хороо, шаардлагатай бол бус нутгийн ба орон нутгийн зөвлөх хороодыг байгуулна. - Эдгээр хорооны бүрэлдэхүүнд орох ажил олгогчид ба ажил олгогчдын төлөөлөгчдийг нь ажил олгогчид ба ажилчдын төлөөлөгчдийн байгууллагуудтай (хэрэв ийм байгууллага байдаг бол) зөвлөлдсөний дараа тэнцүү тооны харьцаагаар томилно. Дараах зорилгоор арга хэмжээ авна:</p>	

<p>(а)Хөдөлмөрийн янз бүрийн товчоодын үйл ажиллагааг аль нэг мэргэжил, аж үйлдвэрийн салбараар (тухайлбал, хөдөө аж ахуй болон дагнасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг ашигтай гэж үзсэн аливаа бусад салбараар) дагнасан шинж чанартай болгоход дэмжлэг үзүүлэх;</p> <p>(б)ажил хайгчдын доторх тодорхой хэсэг, тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг зохих ёсоор хангах.</p>	<p>4.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтнууд нь төрийн албан хаагчид байх бөгөөд тэдний эрх зүйн байдал, ажлын нөхцөл нь Засгийн газрын өөрчлөлт болон гаднын зүй бус нөлөөллөөс хараат бус байж тухайн албаны шаардлагад нийцсэн хэмжээнд тогтвортой ажлын байраар хангагдсан байна.</p> <p>Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний ажилтан нь ажил үүргээ гүйцэтгэхийн тулд зохих бэлтгэл сургалтад хамрагдсан байна.</p>
<p>5.Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний болон зохих тохиолдолд төрийн эрх бүхий бусад байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний байгууллагын өрөө, төхөөрөмж зэргийг ажил олгогчид ба ажилчид сайн дурын үндсэн дээр бүрэн ашиглахыг дэмжихэд чиглэсэн боломжит бүх арга хэмжээг ажил олгогчид ба ажилчдын байгууллага, сонирхогч бусад этгээдтэй хамтран авч хэрэгжүүлднэ.</p>	



	<p>1. Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын эрх зүйн байдлыг үндэсний хууль тогтоомж, практик үйл ажиллагаанд нийцүүлэн, ажил олгогчдын болон ажилчдын илүү төлөөлөл бүхий байгууллагатай зөвлөлдсөний дараа тодорхойлно.</p> <p>2. Гшүүн улс нь хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын үйл ажиллагаа зохицуулах нөхцөлийг, хэрвээ эдгээр нөхцөл нь холбогдох хууль тогтоомж, практик үйл ажиллагаанд өөрөөр зохицуулагдаагүй буюу тодорхойлодоогүй бол зөвшөөрөл буюу гэрчилгээ олгох тогтолцоонд нийцүүлэн тодорхойлно.</p> <p>1 дүгээр зүйлд заасан үйлчилгээ үзүүлж байгаа хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагаар дамжуулан ажил эрхэлж байгаа ажилчдын эвэлдэн нэгдэх, хамтын хэлэлцээ хийх эрхийг хангах арга хэмжээ авна.</p> <p>Эрх бүхий байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сэжиг бүхий ёс бус үйлдэл болон хууран мэхлэх тухай гомдлыг хянаж барагдуулахад ажил олгогчдын болон ажилчдын илүү их төлөөлөл бүхий байгууллагыг оролцуулах зохих техник, шийдвэрлэх журмыг хангасан байна.</p>	<p>Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагаас холбогдох гэрээний дагуу гүйцэтгэж болох үйлчилгээний нэр төрөл, явуулахыг хориглох үйл ажиллагаа болон хүний хөдөлмөрийн эрхийг хангах талаар холбогдох иргэн, хэмжээ, хүлээх хариуцлага, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн эрх үүргийг өргөжүүлэх, үүний дотор хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сэжиг бүхий ёс бус үйлдэл болон хууран мэхлэх тухай гомдлыг хянаж барагдуулах;</p>
<p>11. Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 181 дүгээр конвенц</p>		

	<p>Хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих 17.(а).Гэр бүлийн тухай хууль, хүүхдийн асран хамгаалагчийг тогтоох, эцэг, эхэд ял шийтгэл оногдуулах зэрэг асуудалтай холбоотой шүүх, прокурор, захиргааны шийдвэр гаргах, тайлбар өгөх зэрэгт хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавихыг бүхий л үйл явцын туршид мөрддөг байхад анхаарах.</p>	<p>Холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Хүүхдийн асуудлаар шүүх, прокурор, захиргааны шийдвэр гаргах аливаа үйл ажиллагаанд хүүхдийн эрх ашгийг тэргүүнд тавих;</p>
<p>12.</p>	<p>Үрчлэлт 27.Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн найруулсныг үнэлэхийн зэрэгцээ үрчлэлтийн практикт хангалттай дэвшил гараагүйд Хороо харамсаж байгаа бөгөөд дараах арга хэмжээнүүдийг яаралтай авахыг шаардаж байна.</p>	<p>Эцэг, эхийн эрх, үүрэг, хүүхэд хамгааллын арга хэмжээнд холбогдох эргийн харьяалал, хэрэглэгдэх хууль, шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, хэрэгжүүлэх болон хамтран ажиллах тухай Гаагийн конвенцод нэгдэн орох.</p> <p>Олон улсын хэмжээнд хүүхэд хулгайлахтай холбогдон үүсэх иргэний асуудлын тухай Гаагийн конвенцод нэгдэн орох.</p> <p>Тэжээн тэтгэх үүрэгт хэрэглэгдэх хуулийн тухай протоколд нэгдэн орох.</p>	<p>Хүүхэд үрчлэлтийн практикт дэвшил гаргах;</p>
<p>13.</p>	<p>Ялгааврлан гадуурхахгүй байх.</p>	<p>Холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Шууд болон шууд бусаар ялгааврлан гадуурхах бүх хэлбэр, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй гэх үндэслэлээр ялгааврлан гадуурхалтын эсрэг цогц хуулийг батлах, эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л эрхийг тэгш хүртээмжтэй эдлүүлэхийн тулд ялгааврлан гадуурхалтын нэг хэлбэр болох боломжийн орон сууцанд орох боломжийг үгүйсгэхийг хориглох;</p>



Тав.Эрүүл мэндийн яамны эрхлэх асуудлын хүрээнд:	
<p>НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс 2015 онд өссөн зөвлөмж.</p> <p>Монгол Улс янжуур, дүнсэн тамхи болон бусад тамхины бүтээгдэхүүнд онцгой албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) болон ашгийн татвар ногдуулах татварын бодлого хэрэгжүүлдэг ч Онцгой албан татварын тухай хуулийг 2012 онд шинэчлэн найруулж, дотоодын болон импортын янжуур тамхинд 2.4 ам.доллар, дүнсэн болон бусад задгай тамхинд 1.8 ам.долларын татвар, түүнчлэн бүх тамхины бүтээгдэхүүнд 10%-ийн НӨАТ, 10%-ийн ашгийн татвар ногдуулах болсон. Энэ нь янжуур тамхинд ногдуулах татвар Монгол Улсад 42.4% байгаа нь Сингапур (66%), Филиппин (74%) зэрэг бүсийн бусад улс орнуудтай харьцуулахад бага байгаа юм. Мөн 20 ширхгээр савласан янжуур тамхины үнэ хямд буюу 3000 орчим төгрөг (1.5 ам.доллар) байсан нь Монгол Улс ДЭМБ-ын ТХСК-ийн 6 дугаар зүйлд заасан эрүүл мэндийн зорилтууд болон гишүүн орнуудын 6 дугаар хурлаар баталсан холбогдох удирдамжуудыг хэрэгжүүлж чадахгүйд хүрч байгааг анхааруулсан.</p> <p>Тамхины хяналтын тухай суурь конвенцын 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамжийн зөвлөмжүүдийн хүрээнд тамхины бүтээгдэхүүний үнэ, өрхийн орлогын өсөлтийг харгалзан тамхины бүтээгдэхүүнд ногдуулах татварыг тогтмол нэмж байхыг Сангийн яаманд зөвлөмж болгосон.</p>	<p>Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх. Бүх төрлийн тамхины онцгой албан татварыг нэмэгдүүлэх асуудлыг судалж, шаардлагатай хэмжээгээр нэмэх;</p>
<p>Тамхины хяналтын тухай суурь конвенц</p>	
14.	

		<p>Тамхины хяналтын тухай хуульд онд нэмэлт, өөрчлөлт оруулж, нийтийн хоол, худалдаа, баар, цэнгээний газар, аж ахуйн нэгж, байгууллагад утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийг 300м2-аас доошгүй талбай бүхий барилга байгууламжид нэггээс илүүгүй байхаар тооцоолж байгуулахыг, уг хуулийн 5.1.7 дахь заалтад уг хуулиар хориглосноос бусад гадаад орчин дахь нийтийн эдэлбэр газарт байгуулах утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийн байршил, төсвийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэхээр тус тус өөрчлөлт оруулсан нь конвенцээр хүлээсэн үүргээс ухарсан явдал болсныг онцолсон.</p>	<p>Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх.</p>	<p>Олон нийтийн газрын дотоод орчин, нийтийн тээвэр, ажлын байранд 100% тамхигүй орчин бүрдүүлэх;</p>
		<p>Зургаа.Зам, тээврийн хөгжлийн яамны эрхлэх асуудлын хүрээнд:</p>		
<p>15.</p>	<p>Далайн хөдөлмөрийн тухай конвенц</p>	<p>Засгийн газрын 2 дахь удаагийн тайлангийн хариуд Конвенцын зүйл, заалт болон Актын журам, стандартуудтай холбоотой Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Шинжээчдийн хорооноос 34 хүсэлт, зөвлөмжийг 2021 онд гаргасныг 2022 онд ирүүлсэн. Эдгээр нь конвенцын зүйл, заалтуудыг дотоодын хууль тогтоомжид нарийвчлан тусгах, нэр томъёог нийцүүлэх, зарим асуултуудад тодорхой хариу өгөх зэрэг агуулгатай.</p>	<p>Конвенцын зүйл, заалтуудыг дотоодын хууль тогтоомжид оруулах боломжтой эсэхийг судлах.</p>	<p>Олон Улсын Далайн Байгууллагын заавал дагаж мөрдөх зарим баримт бичиг, дүрэм журам нэмэлт, өөрчлөлтийг шууд хүлээн зөвшөөрөх тул энэ асуудлыг дотоодын хууль тогтоомжид тусган зохицуулахыг Олон Улсын Далайн Байгууллагаас зөвлөдөг. Иймд конвенцын заалтуудыг үндэсний хууль тогтоомжид тусгах;</p>

az emberek számára. A szerzők a szerkesztőségnek ajánlják a munkájukat, és a szerkesztőségnek ajánlják a munkájukat. A szerkesztőségnek ajánlják a munkájukat, és a szerkesztőségnek ajánlják a munkájukat.

A szerkesztőségnek ajánlják a munkájukat, és a szerkesztőségnek ajánlják a munkájukat. A szerkesztőségnek ajánlják a munkájukat, és a szerkesztőségnek ajánlják a munkájukat.

A szerkesztőségnek ajánlják a munkájukat, és a szerkesztőségnek ajánlják a munkájukat. A szerkesztőségnek ajánlják a munkájukat, és a szerkesztőségnek ajánlják a munkájukat.

A szerkesztőségnek ajánlják a munkájukat, és a szerkesztőségnek ajánlják a munkájukat. A szerkesztőségnek ajánlják a munkájukat, és a szerkesztőségnek ajánlják a munkájukat.

A szerkesztőségnek ajánlják a munkájukat, és a szerkesztőségnek ajánlják a munkájukat. A szerkesztőségnek ajánlják a munkájukat, és a szerkesztőségnek ajánlják a munkájukat.

A szerkesztőségnek ajánlják a munkájukat, és a szerkesztőségnek ajánlják a munkájukat. A szerkesztőségnek ajánlják a munkájukat, és a szerkesztőségnek ajánlják a munkájukat.

A szerkesztőségnek ajánlják a munkájukat, és a szerkesztőségnek ajánlják a munkájukat. A szerkesztőségnek ajánlják a munkájukat, és a szerkesztőségnek ajánlják a munkájukat.

Időpontok az Őszi Fesztiválra

A szerkesztőségnek ajánlják a munkájukat, és a szerkesztőségnek ajánlják a munkájukat.



<p>..</p>	<p>..</p>	<p>..</p>	<p>..</p>
<p>..</p>	<p>..</p>	<p>..</p>	<p>..</p>
<p>..</p>	<p>..</p>	<p>..</p>	<p>..</p>
<p>..</p>	<p>..</p>	<p>..</p>	<p>..</p>



	<p>Угтан үгн мэтээр, Үүнтсээс хамгийн багтай хэмээх үүсвэр үүсвэр /CED/C/MIN/CO/11</p> <p>Угтан үгн мэтээр, Үүнтсээс хамгийн багтай хэмээх үүсвэр үүсвэр /CED/C/MIN/CO/11</p> <p>Угтан үгн мэтээр, Үүнтсээс хамгийн багтай хэмээх үүсвэр үүсвэр /CED/C/MIN/CO/11</p>	<p>Угтан үгн мэтээр, Үүнтсээс хамгийн багтай хэмээх үүсвэр үүсвэр /CED/C/MIN/CO/11</p> <p>Угтан үгн мэтээр, Үүнтсээс хамгийн багтай хэмээх үүсвэр үүсвэр /CED/C/MIN/CO/11</p> <p>Угтан үгн мэтээр, Үүнтсээс хамгийн багтай хэмээх үүсвэр үүсвэр /CED/C/MIN/CO/11</p>	<p>Угтан үгн мэтээр, Үүнтсээс хамгийн багтай хэмээх үүсвэр үүсвэр /CED/C/MIN/CO/11</p> <p>Угтан үгн мэтээр, Үүнтсээс хамгийн багтай хэмээх үүсвэр үүсвэр /CED/C/MIN/CO/11</p> <p>Угтан үгн мэтээр, Үүнтсээс хамгийн багтай хэмээх үүсвэр үүсвэр /CED/C/MIN/CO/11</p>
--	--	--	--



<p>2.</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>
<p>3.</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>
<p>4.</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>
<p>5.</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>
<p>6.</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>
<p>7.</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>	<p>تھنڈت لایف سٹائیلیٹو محسن</p>



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар
хот

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.5 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” /цаашид “Хөтөлбөр” гэх/-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай.

3.Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Ёс зүйн хороо /Ц.Амартөгс/-нд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо /Б.Баттөмөр/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Монгол Улсын Их Хурлын 2024 оны
27 дугаар тогтоолын хавсралт

**Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан
сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр
/2024-2030 он/**

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, хариуцлагатай, чадварлаг, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн 2024-2030 онд хэрэгжих дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөр мөн.

Хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судлан эрсдэлийг бууруулах, ёс зүйтэй иргэдээр төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх, сургалт, нөлөөллийн ажлыг идэвхжүүлэх, ёс зүйтэй ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлэх цогц ажиллагааг олон нийтийн оролцоонд тулгуурлан явуулж, ёс зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэснээр ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааны үр дүн сайжирч, ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн төрийн байгууллагын соёл хэвшин, төрд итгэх олон нийтийн итгэл нэмэгдэнэ.

**Зорилго 1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс
урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдамж заавраар хангаж,
зохион байгуулалтыг сайжруулна.**

Зорилт 1.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг бууруулах замаар зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.

1.1.1.байгууллага¹ албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг Ёс зүйн хорооноос баталсан аргачлалын дагуу жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

1.1.2.ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлтэй гэж үнэлэгдсэн албан тушаал эрхэлдэг албан хаагч ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлнэ.

¹ “байгууллага” гэснийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан этгээд, тэдгээрийг харьяалах байгууллагыг хамааруулан ойлгоно.



1.1.3.албан хаагчийн ёс зүйн зөрчил, хариуцлагын бүртгэлийн хуудас нэвтрүүлж, хэрэглэж хэвшүүлнэ.

Зорилт 1.2. Ёс зүйтэй иргэдээр төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх тогтолцоог хөгжүүлнэ.

1.2.1.төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн шалгуурыг үндэсний үнэт зүйл, онцлогт суурилан олон улсын жишиг, хөгжлийн нийтлэг хандлага, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилнэ.

1.2.2.төрийн албан хаагчийг албан тушаалд сонгон шалгаруулж томилоход төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдөх, ёс зүйн төлөвшил, зан үйлийн хэв маягийг тодорхойлох сорил, даалгаврын агуулгаар үнэлэх үйл ажиллагааг өргөжүүлэн, төр, хувийн хэвшил, олон нийтийн оролцоонд тулгуурлан хөгжүүлнэ.

1.2.3.иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулах, томилох, төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулахад ёс зүйн нийтлэг шалгуурыг хангасан эсэхийг эн тэргүүнд харгалзан үзэх зарчмыг мөрдлөг болгон, ёс зүйн зөв төлөвшил, хандлагатай, шударга, хариуцлагатай, нийгмийн зорилгод нийцэх иргэн, албан хаагчийг сонгон шалгаруулж, төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэх тогтолцоог бэхжүүлнэ.

1.2.4.төрийн албаны удирдах албан тушаалын томилгооны сонголд оролцогч этгээдийн ёс зүйн хариуцлагын талаар Ёс зүйн хорооноос санал, дүгнэлт авах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

1.2.5.төрийн албан хаагч нь төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг эн тэргүүнд чанд мөрдөн, ёс зүйн зарчим, хэм хэмжээ, шаардлагуудыг ёсчлон биелүүлж, ёс зүйн аливаа зөрчилгүй ажиллах соёлыг хэвшүүлнэ.

Зорилт 1.3. Төрийн өндөр болон томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайллыг төлөвшүүлнэ.

1.3.1.төрийн өндөр болон томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг чанд мөрдөн, ёс зүйтэй, ил тод, шударга харилцаа, хандлагаар албан хаагчийг үлгэрлэн манлайлах соёлыг төлөвшүүлнэ.

1.3.2.төрийн өндөр болон томилох эрх бүхий албан тушаалтанд тавигдах ёс зүйн манлайллын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, үнэлэх тогтолцоог бий болгоно.

1.3.3.ёс зүйн зөрчил гаргасан бол сайн дураараа ажлаасаа чөлөөлөгддөг, хариуцлага хүлээдэг байх хандлага, ёс зүйн соёлыг төлөвшүүлж, олон нийтийн хяналтыг сайжруулна.

1.3.4.төрийн албан хаагчийн ёс зүйн төлөвшил, байгууллагын нээлттэй соёлыг хэвшүүлэх, дагалдуулах /ментор/, чиглүүлэх /коучинг/ зэрэг хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, төрийн өндөр болон томилох эрх бүхий албан тушаалтны манлайлал, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэн, төрийн албаны мэргэшсэн байдал, залгамж чанарыг хадгалах, хөгжүүлэх, хамтран ажиллах үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулна.

1.3.5.төрийн өндөр болон томилох эрх бүхий албан тушаалтан нь үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг жил бүр олон нийтийн өмнө тайлагнан, сэтгэл ханамжийн судалгаа явуулж, санал, дүгнэлт, зөвлөмжийг дараа жилийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлнэ.

Зорилт 1.4.Ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэсэн төрийн байгууллагын соёлыг хэвшүүлнэ.

1.4.1.төрийн албан хаагч ёс зүй, харилцаа, хандлагаараа олон нийтэд үлгэрлэх соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн төрийн албаны стандартыг боловсруулж, хүний нөөцийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах, сургах, хөгжүүлэх, үнэлж дүгнэх бодлогыг хэрэгжүүлнэ.

1.4.2.төрийн албан хаагчийн тангарагт ёс зүйг эрхэмлэн сахих талаар тусгаж, өргөсөн тангаргаа чандлан мөрдөх соёлыг хэвшүүлэх арга хэмжээг байгууллага төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлнэ.

1.4.3.байгууллага төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх, байгууллагын ёс зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр гаргасан ололт амжилтыг хөхиүлэн дэмжих, алдаршуулан олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлнэ.

1.4.4.төрийн албан хаагч олон нийтийн санаа бодлыг сонсож, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн, иргэдэд хүндэтгэлтэй хандаж, иргэдийн итгэлийг хүлээхүйц харилцааны болон төрийн албаны нэр хүндэд нийцэхүйц соёлыг эзэмшинэ.

Зорилго 2.Төрийн албанд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

Зорилт 2.1.Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллахад дэмжлэг үзүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг идэвхжүүлнэ.

2.1.1.байгууллага төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь сургалтыг тогтмолжуулна.

2.1.2.төрийн албан хаагч бүрийг ёс зүйн багц цагийн цахим сургалтад жил бүр хамруулж, үр дүнг тооцох ажлыг байгууллага зохион байгуулж, Ёс зүйн дэд хороо арга зүйн заавраар хангана. Ёс зүйн хороо багц цагийн сургалтын агуулга, сэдвийг тогтооно.

2.1.3.байгууллага төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг ёс зүйн чиглүүлэх сургалтад хамруулж хэвшүүлнэ.

2.1.4.ёс зүйн хариуцлага хүлээсэн төрийн албан хаагчийг танхимын давтан сургалтад хувийн зардлаар хамруулна.

2.1.5.төрийн албан хаагч ёс зүйн болзошгүй зөрчлөөс ухамсартайгаар зайлсхийх, ёс зүйтэй шийдвэр гаргах болон бусад асуудлыг ёс зүйн сургалтын агуулгад тусгаж, хэрэгжүүлнэ.

Зорилт 2.2.Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлж, дэмжих арга хэрэгслийг өргөжүүлнэ.

2.2.1.байгууллага ёс зүй, шударга байдлыг төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хэлбэр, төрлийг тодорхойлж, төсвийн хамт төлөвлөгөөндөө тусган, хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулна.

2.2.2.байгууллага төрийн албан хаагчид ёс зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, удирдамж, заавраар хангах, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөл бүхий орчныг бүрдүүлж, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

2.2.3.төрийн албаны ёс зүйн зарчим, хэм хэмжээ, шаардлагыг товч, тодорхой, ойлгомжтой хэлбэрээр ангилан төрөлжүүлж, ёс зүйн тайлбар, гарын авлага, зөвлөмж, заавар боловсруулахыг Ёс зүйн хороо нэгдсэн зохицуулалтаар хангаж, байгууллага төрийн албан хаагчид түгээх, сурталчлах, мэдээлэх ажлыг хариуцна.

2.2.4.төрийн албан хаагч бүрийг ёс зүйтэй, шударга ажиллах үүргээ сайтар ухамсарлан ойлгож, чанд мөрдөхөд чиглүүлэн ёс зүйн асуудал хариуцсан албан тушаалтантай харилцах, холбогдох

зөвлөгөөг авах талаарх мэдээллийг хүн бүрд хүргэх ажлыг байгууллага хэрэгжүүлнэ.

2.2.5.байгууллага ёс зүйн төлөвшил, шударга байдлын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, төрийн албан хаагчийн харилцаа, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр хувийн хэвшил, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Зорилго 3.Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх менежментийг сайжруулна.

Зорилт 3.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн биелэлтийг хангах чиглэлээр Ёс зүйн хороог бэхжүүлнэ.

3.1.1.Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хорооны хараат бус, бие даасан байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж, шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулна.

3.1.2.байгууллага Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, мэдээлэл солилцох, уялдаа холбоо, зохицуулалтыг хангах, тайлагнах чиг үүрэг бүхий албан хаагчийг томилж, ажил үүргийн хуваарьт тусган ажиллуулна.

3.1.3.мэргэжлийн болон төрийн үйлчилгээний салбарт тухайн мэргэжлийн ёс зүйн шаардлага, хяналт, хариуцлагыг хангуулах Ёс зүйн дэд хороог байгуулан ажиллуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлнэ.

3.1.4.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн ёс зүйн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжид өөрчлөлт оруулах чиглэлээр санал боловсруулж, шийдвэрлүүлнэ.

3.1.5.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан журам, бусад хуульд заасан эрх хэмжээний хүрээнд батлан мөрдүүлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг Ёс зүйн хорооноос санал авч шинэчлэн баталж, мөрдүүлэх арга хэмжээг авна.

3.1.6.ёс зүйн хариуцлагын төрлийг өргөжүүлэх, бусад зөрчлөөс ялгагдах байдлыг тогтоох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

3.1.7.ёс зүйн зөрчлийг шалган шийдвэрлэх чиглэлээр Ёс зүйн хороо, Ёс зүйн дэд хороодын гишүүдийг мэргэшүүлнэ.

3.1.8. Ёс зүйн хороо Ёс зүйн дэд хороодын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.

3.1.9. Ёс зүйн дэд хороодын эрх, үүрэг, хариуцлагыг үе шаттайгаар нэмэгдүүлэх, ёс зүйтэй төрийн албыг бүрдүүлэх, төлөвшүүлэх ажлыг салбар, байгууллага хариуцах бодлого хэрэгжүүлнэ.

Зорилт 3.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг сахиулах, хэвшүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулна.

3.2.1. төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх, хяналт тавих, хариуцлага тооцох, урамшуулах зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.2.2. төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж, дүрмийг сурталчлан таниулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвлөгөө өгөх, зөрчлийг мэдээлэх зэрэг чиглэлээр нөлөөллийн аяныг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулан үр дүнг тооцно.

3.2.3. төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэвшүүлэх, баримтлан ажиллахад чиглэсэн үйл ажиллагааг байгууллагын удирдлага манлайлан, Ёс зүйн дэд хорооны дэмжлэгтэйгээр тогтмол хэрэгжүүлнэ.

Зорилт 3.3. Төрийн албанд ёс зүйн зөрчлийг мэдээлэх тогтолцоог бүрдүүлж, олон нийтийн хяналтыг идэвхжүүлнэ.

3.3.1. байгууллага нь иргэн, албан хаагчаас төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гомдол, мэдээлэл хүлээн авч, ёс зүйн зөрчил хянан шийдвэрлэх үйл ажиллагааны мэдээ, тайланг олон нийтэд тогтмол мэдээлж хэвшинэ.

3.3.2. ёс зүйн гомдол, мэдээлэл, зөрчил, хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн бүрэлдэхүүн болгон хөгжүүлж, үйл ажиллагаандаа тогтмол ашиглана.

3.3.3. байгууллага ёс зүйн зөрчилд хариуцлага тооцсон талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлж, хяналт тавих боломжийг бүрдүүлнэ.

Зорилго 4. Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангана.

Зорилт 4.1. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг иргэн, хувийн хэвшил, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагын бодит оролцоонд тулгуурлан үр дүнтэй хяналтыг бэхжүүлэх үйл ажиллагааг цогц байдлаар зохион байгуулна.

4.1.1. эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төр ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий хандлагаар нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг байгууллага манлайлан, иргэн, хувийн хэвшил, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагыг татан оролцуулна.

4.1.2. төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн сэтгэл зүйд эергээр нөлөөлөх зорилгоор үндэсний контентыг бүтээж, түгээнэ.

4.1.3. хүүхэд, залуучуудын шударга, зөв, ёс зүйтэй байх үзэл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн сэдэв, агуулга бүхий контентыг монгол хүний ахуй, соёл, зан чанарт нийцүүлэн бүтээх, түгээх ажлыг иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.1.4. иргэдийн ёс зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийг бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилт, арга хэмжээтэй уялдуулан, ёс зүйн боловсролыг дээшлүүлэх нөлөөллийн ажлыг бүх талын оролцоотойгоор гүйцэтгэж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.1.5. төрийн албан хаагч нийгмийг соён гэгээрүүлэгч байх, шударга, ёс зүйтэй харилцаа, хандлагаар иргэдийг үлгэрлэн дагуулах байдлаар нийгмийн нөлөөлөгч байх бодлого, үйл ажиллагааг тасралтгүй хөгжүүлнэ.

Зорилт 4.2. Судалгаа шинжилгээний үр дүнд суурилсан ёс зүйн үнэлгээг чанаржуулна.

4.2.1. төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчлийн талаарх олон нийтийн санаа бодлыг тандах судалгааг жил бүр зохион байгуулж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглаж хэвшинэ.

4.2.2. байгууллага ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг жил бүр судалж, нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлон зөрчлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.



4.2.3.төрийн албаны ёс зүйн индексийг нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

4.2.4.ёс зүйн судалгаа шинжилгээ, хяналт, үнэлгээний ажилд хувийн хэвшил, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, судалгааны байгууллага, мэргэшсэн баг, судлаачийн оролцоог хангана.

Зорилт 4.3. Ёс зүйн чиглэлээр хөндлөнгийн хяналтыг хөхиүлэн дэмжинэ.

4.3.1.төрийн албан хаагчийн ёс зүй, шударга байдлын төлөвшилд өөрийн үнэлгээ өгөх, хамт олон, удирдлага, хамтран ажиллагчаар иргэн, олон нийтийн оролцоотойгоор хөндлөнгийн үнэлгээ гүйцэтгүүлэх тогтолцоог бэхжүүлнэ.

4.3.2.төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, албан тушаалд дэвшүүлэх, шагнах, урамшуулах, сургалтад хамруулах асуудлыг шийдвэрлэхэд төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжид заасан шударга байх зарчим, шаардлагыг мөрдөх, шударга ажилласан байдал, ёс зүйн хариуцлага хүлээсэн талаарх хөндлөнгийн дүгнэлтийг харгалзан үзэх тогтолцоог бүрдүүлнэ.

4.3.3.төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдөж хэвшсэн болон ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ, сургалт, хүмүүжлийн ажилд оролцсон байдал, санаачилга, идэвх зүтгэл гаргах, сайн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр манлайлсан байдлыг албан хаагчийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт болгоно.

4.3.4.байгууллага, томилох эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг биелүүлэх чиглэлээр гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланг жил бүр олон нийтэд мэдээлнэ.

---oOo---

Mindful Folio – on Yaka Horik and Doodlegak

Хүснэгт 1

Түгш

Утга

᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар

Утга
᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар

᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар

᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар

᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар

᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар

᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар
᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар

᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар

᠑᠙᠙᠗ – ᠒᠐᠒᠔ оны ᠑᠒ сар



Үргэлжлэн ажлаар ажиллаж байгаа үйлдвэр, ажлаас
дээшлэн үйлдвэрлэлээр ажиллаж байгаа үйлдвэр

Монгол Улсын Засаг Заргаас 2023 оны 11 дугаар
саяат, 2023 оны 11 дугаар саяат, 2023 оны 11 дугаар саяат
МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАРГААС

Монгол Улсын Засаг Заргаас 2023 оны 11 дугаар саяат, 2023 оны 11 дугаар саяат, 2023 оны 11 дугаар саяат
МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАРГААС

Монгол Улсын Засаг Заргаас 2023 оны 11 дугаар саяат, 2023 оны 11 дугаар саяат, 2023 оны 11 дугаар саяат
МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАРГААС

Монгол Улсын Засаг Заргаас 2023 оны 11 дугаар саяат, 2023 оны 11 дугаар саяат, 2023 оны 11 дугаар саяат
МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАРГААС

Монгол Улсын Засаг Заргаас 2023 оны 11 дугаар саяат, 2023 оны 11 дугаар саяат, 2023 оны 11 дугаар саяат
МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАРГААС

Монгол Улсын Засаг Заргаас 2023 оны 11 дугаар саяат, 2023 оны 11 дугаар саяат, 2023 оны 11 дугаар саяат
МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАРГААС

Монгол Улсын Засаг Заргаас 2023 оны 11 дугаар саяат, 2023 оны 11 дугаар саяат, 2023 оны 11 дугаар саяат
МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАРГААС



1.6.6.2. Կնիքով խմելու խմորի փոխարինումը կատարելու ընդհանուր կանոնները սահմանափակված չեն:

1.6.6.3. Կնիքով խմելու խմորի փոխարինումը կատարելու ընդհանուր կանոնները սահմանափակված չեն:

1.6.7. Կնիքով խմելու խմորի փոխարինումը կատարելու ընդհանուր կանոնները սահմանափակված չեն:

1.6.8. Կնիքով խմելու խմորի փոխարինումը կատարելու ընդհանուր կանոնները սահմանափակված չեն:

1.6.9. Կնիքով խմելու խմորի փոխարինումը կատարելու ընդհանուր կանոնները սահմանափակված չեն:

1.6.10. Կնիքով խմելու խմորի փոխարինումը կատարելու ընդհանուր կանոնները սահմանափակված չեն:

1.6.11. Կնիքով խմելու խմորի փոխարինումը կատարելու ընդհանուր կանոնները սահմանափակված չեն:

1.6.12. Կնիքով խմելու խմորի փոխարինումը կատարելու ընդհանուր կանոնները սահմանափակված չեն:

1.6.13. Կնիքով խմելու խմորի փոխարինումը կատարելու ընդհանուր կանոնները սահմանափակված չեն:

1.6.14. Կնիքով խմելու խմորի փոխարինումը կատարելու ընդհանուր կանոնները սահմանափակված չեն:



3.3.6.1. Өндөржүүлэг ажлын үр дүнд хөгжлийн үйлчилгээний үйлчилгээний өргөтгөл...

3.3.6.2. Өндөржүүлэг ажлын үр дүнд хөгжлийн үйлчилгээний үйлчилгээний өргөтгөл...

3.3.6.3. Өндөржүүлэг ажлын үр дүнд хөгжлийн үйлчилгээний үйлчилгээний өргөтгөл...

3.3.6.4. Өндөржүүлэг ажлын үр дүнд хөгжлийн үйлчилгээний үйлчилгээний өргөтгөл...

3.3.6.5. Өндөржүүлэг ажлын үр дүнд хөгжлийн үйлчилгээний үйлчилгээний өргөтгөл...

3.3.6.6. Өндөржүүлэг ажлын үр дүнд хөгжлийн үйлчилгээний үйлчилгээний өргөтгөл...

3.3.6.7. Өндөржүүлэг ажлын үр дүнд хөгжлийн үйлчилгээний үйлчилгээний өргөтгөл...

3.3.6.8. Өндөржүүлэг ажлын үр дүнд хөгжлийн үйлчилгээний үйлчилгээний өргөтгөл...

3.3.6.9. Өндөржүүлэг ажлын үр дүнд хөгжлийн үйлчилгээний үйлчилгээний өргөтгөл...

3.3.6.10. Өндөржүүлэг ажлын үр дүнд хөгжлийн үйлчилгээний үйлчилгээний өргөтгөл...

3.3.6.11. Өндөржүүлэг ажлын үр дүнд хөгжлийн үйлчилгээний үйлчилгээний өргөтгөл...

3.3.6.12. Өндөржүүлэг ажлын үр дүнд хөгжлийн үйлчилгээний үйлчилгээний өргөтгөл...



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 35

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалт”-ын 3 дахь хэсгийн “зориулалтын дагуу ашиглагдахгүй байгаа хар болон өнгөт төмөрлөгөөр хийсэн сэлбэг” гэсний дараа “, автомашины нүүрсэн яндан, катализатор, тэдгээрийн эд анги, хаягдал, өөдөс” гэж нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Индриг Фоль_ ца Үлд Норгъ ца Додлигъ

Амгын Агуйн Гэс

᠘᠙

᠒᠐᠒᠔ он ᠒ сар ᠒᠙ өдөр

Амгын Гэсний
Ажлын Дугуйн ᠒᠐᠒᠔

᠒᠐᠒᠔ он ᠒ сар ᠒᠙ өдөр. Амгын Агуйн Гэсний Ажлын Дугуйн ᠒᠐᠒᠔ он ᠒ сар ᠒᠙ өдөр. Амгын Агуйн Гэсний Ажлын Дугуйн ᠒᠐᠒᠔ он ᠒ сар ᠒᠙ өдөр.

᠒᠐᠒᠔ он ᠒ сар ᠒᠙ өдөр. Амгын Агуйн Гэсний Ажлын Дугуйн ᠒᠐᠒᠔ он ᠒ сар ᠒᠙ өдөр. Амгын Агуйн Гэсний Ажлын Дугуйн ᠒᠐᠒᠔ он ᠒ сар ᠒᠙ өдөр.

᠒᠐᠒᠔ он ᠒ сар ᠒᠙ өдөр. Амгын Агуйн Гэсний Ажлын Дугуйн ᠒᠐᠒᠔ он ᠒ сар ᠒᠙ өдөр.

Амгын Гэсний
Ажлын Дугуйн ᠒᠐᠒᠔

᠒᠐᠒᠔ он ᠒ сар ᠒᠙ өдөр



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар
хот

**Монгол Улс дахь хүний эрх, эрх
чөлөөний байдлын талаарх 23 дахь
илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан
сэргийлэх үйл ажиллагааны 2023
оны тайланг хэлэлцсэнтэй
холбогдуулан авах зарим
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцээд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, дэмжих чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн талаар:

а/байгаль орчны салбарт мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, эрх зүйн актын давхардал, зөрчил, хийдлийг хүний эрхийн шалгуурт нийцүүлэн өөрчлөх саналыг боловсруулж, агаар, орчны бохирдлын асуудлыг үндэсний хэмжээнд хариуцах бүтцийг тодорхойлж, салбар хоорондын уялдаа холбоог ханган үр дүнтэй ажиллах тогтвортой тогтолцоог бүрдүүлэх;

б/агаар, ус, хөрс, орчны бохирдлыг бууруулах бодлогыг урт, дунд, богино хугацааны зорилтод нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх, тандалт, хяналт шинжилгээний сорьцын мэдээллийн сан бүрдүүлж, дотоод орчны чанарт тавигдах суурь үзүүлэлт бүхий шаардлага, стандартыг шинэчлэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, дотоод орчны чанарын лабораторийн хэмжилтийн дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох харилцааг зохицуулах;

в/хөрсний болон усны бохирдлыг бууруулах, хог хаягдлын төлөвлөгөөг батлах, усны менежментийн төлөвлөгөөг шинэчлэх, хөрсийг

нөхөн сэргээх, ногоон бүс байгуулах, ургамал мод тарих зэрэг арга, технологийг хэрэглээнд нэвтрүүлэх, ариун цэврийн байгууламж (нүхэн жорлон)-ийг стандартад нийцсэн эко ариун цэврийн байгууламжаар солих арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хяналт тавих;

г/орчны бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө, урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллийг олон нийтэд тогтмол, хүртээмжтэйгээр хүргэх, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагааг сайжруулах.

2/Боловсролын салбар дахь хүний эрхийн асуудлаар:

а/бүх шатны боловсролын сургалтын байгууллага, дотуур байрны гадаад болон дотоод орчны аюулгүй байдлын стандартыг хангуулах, боловсролын байгууллагын барилга, өргөтгөлийн ажилд төр, иргэний хамтарсан хөндлөнгийн хараат бус хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;

б/хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн эрхийг хангах хүрээнд тэднийг дэмжих төв ажиллуулж, тохирох орчныг бүрдүүлэх, тусгай сургалтын хэрэглэгдэхүүн бий болгох, эцэг, эхийн оролцоог хангаж, багшийн туслахаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, багш, багшийн туслах, ажилтанд нэмэгдэл хөлс олгох хуулиар тогтоосон арга хэрэгслийг үр дүнтэй хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын цогц арга хэмжээ авах;

в/хувийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, шалгуурыг нарийвчлан тогтоох, хүүхдийн өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлага, стандарт, эрх зүйн орчныг бүрдүүлэх.

3/Хүүхдийн эрхийн зарим асуудлын талаар:

а/улсын хэмжээнд хагас болон бүтэн өнчин, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй, өрх толгойлсон, айлд амьдарч байгаа зэрэг хүүхдүүдийн бүртгэлийг хийж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, хяналт тавих механизмыг сайжруулах, эдгээр эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн санг бүрдүүлж, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, тусгайлсан бодлого боловсруулан хэрэгжүүлэх;

б/хүүхдийн асрамж халамжийн төвөөс гарч байгаа өнчин хүүхдийг ажлын байр, орон байртай болоход бодитой дэмжлэг үзүүлэх,

тэдгээр хүүхдийг их, дээд сургуульд суралцахад боловсролын зээлийн санхүүжилтээр үнэ төлбөргүй суралцуулах, суралцагчийн тэтгэлгийн асуудлыг хамтад нь шийдвэрлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

в/аймаг, дүүрэг бүрд байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд зориулсан нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, боловсрол олгох, өдөр өнжүүлэх хөгжлийн төв болон байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн төрөлжсөн асрамж халамжийн төв байгуулах, холбогдох санхүүжилт, хүний нөөцийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх.

4/Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдал, хүний эрхийн талаар:

а/гэр бүлийн боловсрол олгох, зорилтот гэр бүлийг дэмжих, нийгмийн үйлчилгээг сайжруулах, хүчирхийлэл, ахуйн хүрээний сөрөг зан үйлээс хамгаалах асуудлыг тусгасан гэр бүлд чиглэсэн салбар дундын цогц бодлого батлах, холбогдох санхүүжилтийг шийдвэрлэх;

б/өсвөр насныхны нөхөн үржихүй, эрүүл мэндийн хэрэгцээнд тулгуурласан урьдчилан сэргийлэх, хамгаалах, тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэхэд чиглэсэн тусгайлсан төсөв, санхүүжилтийг шийдвэрлэх;

в/ахмад настан, хүүхэд, байнгын хэвтрийн өвчтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг асрах үйлчилгээг даатгалын зарчмаар санхүүжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

г/шүүхийн шийдвэрээр тогтоосон хүүхдийн тэтгэлгийг хугацаанд нь төлөхгүй байгаа болон хуулиар хүлээсэн хүүхдээ хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх үүргийг биелүүлэх зохицуулалтыг хууль тогтоомжоор тодорхойлох, энэхүү үүргээ биелүүлэхгүй байгаа эцэг, эх, асран хамгаалагчдад хүлээлгэх хуулийн хариуцлагыг нэмэгдүүлэх, нөхөн төлөгдөх нөхцөлтэй “Хүүхдийн тэтгэлгийн сан” байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

5/Хүний эрх хамгаалагчийн асуудлаар:

а/төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааны талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг батлах, ашгийн бус байгууллага байгуулж, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хэрэгжүүлэх үзэл баримтлалын үүднээс Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн боловсруулах;

б/хүний эрх хамгаалагч, шүгэл үлээгчийн аюулгүй байдлыг үр дүнтэй хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Гэрч, хохирогчийг хамгаалах бие даасан механизмыг бий болгох, байгаль хамгаалагчийн ажлын байрны үнэлгээг хийж, албан үүргээ гүйцэтгэх баталгааг бүрдүүлэх.

6/Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн асуудлаар:

а/хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийг нийгэмд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх механизмыг олон улсын туршлагад нийцүүлэн бий болгох, ингэхдээ төрийн бус байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх бодлого баримтлах;

б/хорих ял шийтгүүлсэн хүнийг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх, нийгмээс тусгаарлахгүйгээр ялын зорилгыг хангах ажлын бодит үр нөлөөг дээшлүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;

в/хорих ангийн тоог бууруулах урт хугацааны зорилгын үүднээс хорих ангийг дагнасан сургалт, үйлдвэрлэлийн хэлбэрээр зохион байгуулах бодлого гаргаж, хэрэгжүүлэх;

г/хорихоос суллагдахад бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх.

7/Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцооны талаар:

а/Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын 33 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих бүтцийг тогтоон хуульчлах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үүргээ биелүүлээгүй хүн, хуулийн этгээдэд оногдуулах хариуцлагыг Төрийн албаны тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн хуулиудад нарийвчлан тусгах, хариуцлага тооцох механизмыг тодорхой болгох;

б/бүх шатны сонгуульд нэр дэвшиж байгаа хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчид сурталчилгааны материал хэвлүүлэх, түгээх, хүртээмжтэй тээврийн хэрэгсэл, сурталчилгааны байраар хангах, дохионы хэлмэрч, хувийн туслах ажиллуулах зэрэг дэмжих үйлчилгээ авахад төрөөс санхүүгийн дэмжлэг, төлбөр, татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн зохицуулалт бий болгох;

в/хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чадавхжуулах, бие даан шийдвэр гаргах, сонголт хийх хэвшил, дадал төлөвшүүлэх сургалт,

нөлөөллийн үйл ажиллагааг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв, Насан туршийн суралцахуйн төвийг түшиглэн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

г/Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд чуулганы танхим, хуралдааны мэдээлэл хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, онцлог хэрэгцээнд нийцсэн байх, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнд шаардлагатай хувийн туслах, дохионы хэлмэрч, туслах технологиор хангах зохицуулалт тусгах;

д/Монгол Улсын цахим хөгжлийн бодлогод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанар, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх шинэ технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд чиглэсэн судалгаа, хөрөнгө оруулалтын арга хэмжээг тусган хэрэгжүүлэх.

8/Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах чиглэлээр:

а/шүүхийн шийтгэх тогтоолд заасан нийт хугацаанд хорих ангид ял эдэлж байхдаа өөр гэмт хэрэгт шалгагдаж, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцохгүй байгаа нь хүний халдашгүй, чөлөөтэй байх Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг зөрчиж байж болзошгүй тул Эрүүгийн хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон хугацааг ялтны эдлэх ялд оруулан тооцно.” гэсэн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсронгуй болгох.

9/Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

а/Монгол Улсын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүхийн эсрэг Дэд хорооноос Монгол Улсад өгсөн зөвлөмж (2016), “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо Монгол Улсад хийсэн айлчлал: ажиглалт болон оролцогч улсад хандсан тайлан, зөвлөмжүүд” (2017), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсгийн Монгол Улсад 2022 онд хийсэн айлчлалын тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Зөвлөлийн 2023 оны 54 дүгээр хуралдаанаар хэлэлцэн баталж Монгол Улсад ирүүлсэн Зөвлөмжид нийцүүлэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг зохицуулсан холбогдох зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулан, боловсронгуй болгох;



б/Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 22 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрсөн мэдэгдэл хийж Нэгдсэн Үндэсний Байгууллагын Эрүү шүүлтийн эсрэг хороонд уламжлах асуудлыг холбогдох журмын дагуу судлан шийдвэрлэх.

2.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын болон гишүүний зөвлөмж, шаардлагыг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих, хэрэгжүүлээгүй төрийн байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох саналаа боловсруулж Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс /Д.Сүнжид/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/-нд даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох, Монгол Улсын эм зүйн салбарын бүртгэл, чанар, хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хянан шалгах түр хорооны санал, дүгнэлтийн хүрээнд эм зүйн салбарын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр дараах асуудалд анхаарал хандуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангах, зохистой хэрэглээг төлөвшүүлэхтэй холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төслийг дараах агуулгын хүрээнд боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх:

а/Хүний эмийн зөвлөл, салбар зөвлөлийн томилгооны болон үйл ажиллагааны журмыг нарийвчлан зохицуулах, төлөөллийн зохистой байдал, тавигдах шалгуур, ажиллах хугацаа, хувийн ашиг сонирхлоо мэдүүлэх, түүнд хяналт тавих, санал өгөх нууцлал, хурлын тэмдэглэл болон баримт бичгийг архивлах зэрэг асуудлыг тодорхой тусгах;

б/эмийн хатуу зохицуулалттай гадаад улсын итгэлцлийн зохистой дадлыг нэвтрүүлэх;

в/зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орох эмийг сонгох шалгуурыг тодорхой болгож, зах зээлийн бодит үнэд тулгуурлан үнэлдэг болох, эмийн үнийг хянах, борлуулалтын үнийн дээд хязгаарын зохицуулалтыг нарийвчлан тусгах;

г/Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын чиг үүргийг тодорхой болгон, эрх зүйн чадамжийг дээшлүүлж, байр, санхүүжилтийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх;

д/Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын чиг үүрэгт эм, эмнэлгийн хэрэгслийг импортлох, экспортлох зохицуулалтын талаар тусгах;

2/эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, хангамж, хүртээмжийг нэгдсэн цахим тогтолцоогоор хянах, зохицуулах зорилгоор Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар болон Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар зэрэг төрийн байгууллагуудын мэдээллийг нэгтгэх;

3/эмийн үнийн өсөлтөд олон нийтээс тавих хяналтыг бий болгох зорилгоор нийлүүлэлт, борлуулалтын үнийн мэдээллийг ижил нэгжээр цахим хэрэгслээр дамжуулан нээлттэй болгох;

4/LICEMED (druginfo.mohs.mn) системийн тоног төхөөрөмжийн хамгаалалтыг нэмэгдүүлж, аюулгүй байдлын шаардлага, дэд бүтцийг сайжруулах;

5/бүртгэлийн заавраас зөрүүтэй, чанаргүй болон хадгалалтын хугацаа дууссан, горим алдагдсан эм, эмийн бүтээгдэхүүний устгалын бүртгэлийг цахимжуулах арга хэмжээг авах;

6/Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын харьяа Эм шинжлэх лабораторийг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторитой нэгтгэж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, лабораторийн байр, шаардлагатай урвалж бодис, багаж, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг төсвийн болон олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор шийдвэрлэх;

7/эмийн цувралын чанарыг санамсаргүй түүврийн аргаар хянах тогтолцоог нэвтрүүлэх;

8/иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд эмийн зохистой хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа явуулах;

9/хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр холбогдох төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагааг уялдуулж, хугацаатай үүрэг даалгавар өгөх;

10/Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлахыг хориглох, сурталчилсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх талаар төрийн байгууллагуудын уялдааг хангах;



11/Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны санал, дүгнэлтийг хэрэгжүүлэх;

12/Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 60 дугаар тогтоолоор байгуулагдсан Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо (цаашид “Хянан шалгах түр хороо” гэх) Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны хяналт шалгалтаар илэрсэн асуудлыг шуурхай шалгаж, зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг авч, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй албан тушаалтны хариуцлагын асуудлыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.

2.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлд хийсэн хяналт шалгалтын явцад төрийн байгууллага дахь эм хангамжийн байгууллагын хамаарал, эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд үүссэн байж болзошгүй хувийн ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг холбогдох хуулийн дагуу шалган, иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэхийг Авлигатай тэмцэх газар /З.Дашдаваа/-т, хяналт шалгалтаар илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг холбогдох хуулийн дагуу шалгаж, шийдвэрлүүлэхийг Монгол Улсын ерөнхий прокурор Б.Жаргалсайханд тус тус зөвлөсүгэй.

3.Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо /П.Анужин/-нд тус тус даалгасугай.

4.Энэ тогтоолыг 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

միջոցով հասնում է շեղումների, որոնք հանգցում են մեծ կորուստների, որոնք ընդհանուր առմամբ կրելի են հանգցումը, որի արդյունքում շեղումները կտանան ավելի մեծ ծանրություն։

Հնարավոր է, որ շեղումների առաջին շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն նախնիների և հայրերի մահը։ Գաղթի շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն հայրերի մահը։ Գաղթի շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն հայրերի մահը։ Գաղթի շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն հայրերի մահը։ Գաղթի շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն հայրերի մահը։

Մենք հավատում ենք, որ այս ժամանակահատվածը կտևի մինչև 1920-ական թվականները, որոնք կհանգցնեն հայրերի մահը։ Գաղթի շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն հայրերի մահը։ Գաղթի շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն հայրերի մահը։ Գաղթի շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն հայրերի մահը։ Գաղթի շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն հայրերի մահը։

Մենք հավատում ենք, որ այս ժամանակահատվածը կտևի մինչև 1920-ական թվականները, որոնք կհանգցնեն հայրերի մահը։ Գաղթի շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն հայրերի մահը։ Գաղթի շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն հայրերի մահը։ Գաղթի շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն հայրերի մահը։ Գաղթի շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն հայրերի մահը։

Հնարավոր է, որ շեղումների առաջին շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն նախնիների և հայրերի մահը։ Գաղթի շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն հայրերի մահը։ Գաղթի շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն հայրերի մահը։ Գաղթի շրջանը կսկսվի 1920-ական թվականներից, որոնք կհանգցնեն հայրերի մահը։



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 05 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн аудитын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 65 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар өөрчлөн баталсугай.

2. Энэ тогтоолыг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Монгол Улсын Их Хурлын 2024 оны
39 дүгээр тогтоолын хавсралт

**ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧИЙН
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ /төгрөгөөр/
1	Тамгын дарга	3 576 000
2	Үндэсний аудитын газрын бүтцийн нэгжийн дарга, захирал, тэргүүлэх аудитор	3 336 000
3	Үндэсний аудитын газрын хэлтэс, албаны дарга, менежер	3 180 000
4	Үндэсний аудитын газрын ахлах аудитор, ахлах шинжээч	3 036 000
5	Үндэсний аудитын газрын аудитор, шинжээч	2 856 000
6	Орон нутаг дахь Төрийн аудитын газрын дарга	3 180 000
7	Орон нутаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга, аудитын менежер	3 036 000
8	Орон нутаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор, ахлах шинжээч	2 856 000
9	Орон нутаг дахь Төрийн аудитын газрын аудитор, шинжээч	2 556 000

---oOo---

Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр
дээр хөрөнгийн үйлдвэрлэл ажиллагааны

Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр
дээр хөрөнгийн үйлдвэрлэл ажиллагааны

№/д	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр
1	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр
2	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр
3	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр
4	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр
5	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр
6	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр
7	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр
8	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр	Үйлдвэр, ажлаар ажилладаг хэргийн үйлдвэр



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 5.5

Индекс: 200003